



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/183

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тайландын хаант улсын Паттаяа хотод 2024 оны 03 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулагдах Евразийн нийгмийн ажлын 15 дугаар форумд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч Цамбагаравын Болормааг оролцуулсугай.

2.Замын зардал 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0380

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 13 -ны өдрийн 131 дугаар захирамжийн хавсралт



**“БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ЗОРИЛТ, “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ОРОН НУТАГТ СУРТАЛЧЛАХ” АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

№	Зохион байгуулах арга хэмжээ	Хугацаа	Шагнал урамшуулал	Нийт зардал (мян.төг)
1	Зэвсэгт хүчний 339, 342 дүгээр ангиудад хугацаат цэргийн алба хааж байгаа цэрэг дайчдад “Нэг нутгийн уулзалт өдөрлөг”-ийн арга хэмжээ зохион байгуулах;	03.25-29	АИ-92 250x2470=617,500 Дурсгалын зүйл 2x300,000=600,000 ХЦАХ-ын бэлэг 38x 20,000=760,000	1,977,500
2	Политехникийн коллежийн оюутан суралцагч, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Тусгаар тогтнол-үндэсний эрх чөлөө” сэдвээр “ЭСЭЭ” бичлэгийн уралдаан;	03.04 03.15	I байр 80,000 II байр 60,000 III байр 40,000 Тусгай байр 2x30,000=60,000 Өргөмжлөл 5x35,000=175,000	415,000
3	Арвайхээр сумын ЕБС-ийн дунд ангийн сурагчдад Цэрэг-эх орны сэдвээр “АХА” цэнгээнт нэвтрүүлэг;	03.09	I байр 80,000 II байр 60,000 III байр 40,000 Тусгай байр 2x30,000=60,000 Өргөмжлөл 35,000x5=175,000	415,000
4	Политехникийн коллежийн оюутан суралцагч, ЕБС-ийн ахлах ангийн ахлах ангийн сурагчдыг Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцуулах “Эх орон бидхий бахархал” сэдвээр уулзалт ярилцлага зохион байгуулах; (40-45 хүүхэд)	03.11 14.00-16.00 цагт	ДТ 45x4060=182,700 Хоолны зардал 45x5000=225,000	407,700
5	Зэвсэгт хүчний анги, салбар, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид болон иргэд, олон нийтийн дунд “Эх орон танаа” цэргийн дуу дуулаачдын аймгийн уралдаан;	03.16	I байр 250,000 II байр 200,000 Шүүгчдийн зардал 3x50,000=150,000	600,000
6	Аймгийн ЗДТГ, Зэвсэгт хүчний анги, салбар, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын дунд	03.12-17	I байр 300,000 II байр 250,000 III байр 200,000	1,080,000



			Өргөмжлөл 45000x4=180000	
7	Аймгийн Засаг даргын нэрэмжит “Арвайхээр” цэргийн хүрээний Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд зохион байгуулагдах “Марш тактикийн аварга тасаг” шалгаруулах тэмцээн;	03.14-15	I байр 500,000 II байр 400,000 III байр 300,000 Тусгай байр 200,000 Шилжин явах цом 100,000 Өргөмжлөл 4x50,000=200,000 Медаль 39x7000=273,000 Батламж 40x3000=120,000	2,093,000
8	“Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 103 жилийн ойд зориулсан баярын хурал, шагнал гардуулах ёслол, хүндэтгэлийн концертын арга хэмжээг зохион байгуулах;	03.18	LED дэлгэцийн түрээс 150,000 Хөтлөгч, дуучид зардал 3x50,000=150,000	300,000
9	“Арвайхээр цэргийн хүрээ”-ний нэгдсэн тооллогын баярын салют буудах;	03.17	Салют 3 хайрцаг 3x250,000=750,000	750,000
10	Аймгийн удирдлага Зэвсэгт хүчний анги салбар, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагууд болон “Бэлтгэл хурандаа” нарт хүндэтгэл үзүүлэх;	03.18	20 хүн – 35,000=700,000	700,000
Бүгд				8,738,200